



НИЙСЛЭЛИЙН ТАТВАРЫН ГАЗРЫН ДЭРГЭДЭХ  
МАРГААН ТАСЛАХ ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ

2019 оны 12 сарын 04 өдөр

Дугаар 069

Улаанбаатар хот

**"Евро эйшия реманд пактурин сервис" ХХК-ийн гомдлын тухай**

Нийслэлийн татварын газрын дэргэдэх Маргаан таслах зөвлөлийн хуралдааныг Д.Сайханчулуун даргалж, гишүүд Х.Төмөрбаатар, Ё.Наранбилэг, Д.Баяраа, Б.Төгслхам, Ц.Алтанцэцэг, Д.Мөнхтуул, нарийн бичгийн дарга Ж.Эрдэнэбүрэн нарын бүрэлдэхүүнтэй, "Евро эйшия реманд пактурин сервис" ХХК-аас Баянзүрх дүүргийн Татварын хэлтсийн татварын улсын байцаагчийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 0290951 дүгээр шийтгэлийн хуудсанд гаргасан гомдлыг, тус компанийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Д.Сүхээ, Баянзүрх дүүргийн Татварын хэлтсийн татварын улсын байцаагч Г.Баярмаа нарыг оролцуулан магадлагч-татварын улсын байцаагч Г.Ганбат магадалгаа хийж, танилцуулснаар хянан хэлэлцэв.

**ТОДОРХОЙЛОХ НЬ**

1. "Евро эйшия реманд пактурин сервис" ХХК-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Д.Сүхээ нь Маргаан таслах зөвлөлд ирүүлсэн гомдолдоо: "Татвар төлөгч нь 2014 онд 13,036,719.08 төгрөгийн, 2015 онд 4,677,184.44 төгрөгийн дүн бүхий үндсэн хөрөнгийн худалдан авалт хийсэн. Тус худалдан авалтад төлсөн нэмэгдсэн өртгийн албан татварын хасалт хийсэн нь үнэн болно. Тухайн хугацаанд хүчин төгөлдөр мөрдөж байсан НӨАТ-ын хуулиар үндсэн хөрөнгийн худалдан авалтад төлсөн нэмэгдсэн өртгийн албан татварыг хасалт хийхээр зохицуулагдсан байсан тул татварын улсын байцаагчийн оногдуулсан татварыг төлөх үндэслэлгүй болно. Мөн 2016 онд 827,000.00 төгрөгийн үнэ бүхий үндсэн хөрөнгийг худалдан авсан нь үнэн бөгөөд тухайн худалдан авалтад төлсөн нэмэгдсэн өртгийн албан татварын хасалт хийгээгүй болно. Учир нь 2016 оны 01-р сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулиар үндсэн хөрөнгийн худалдан авалтад төлсөн татварыг хасахгүй байхаар зохицуулсан тул хасалт хийгээгүй тайлагнасан. Иймд манай гомдлыг хянан үзэж, 0290951 тоот шийтгэлийн хуудсыг бүхэлд нь хүчингүй болгож өгөхийг хүсье." гэж тэмдэглэсэн

2. Баянзүрх дүүргийн Татварын хэлтсийн татварын улсын байцаагч Ш.Гэрэлзаяа, Г.Баярмаа нар ирүүлсэн тайлбартаа: "Баянзүрх дүүргийн Татварын хэлтсийн хяналт шалгалтын тасгийн татварын улсын байцаагч Г.Баярмаа, Ш.Гэрэлзаяа бид 2018 оны татварын эрсдэлд суурилсан төлөвлөгөө, «Татварын хяналт шалгалт хийх ерөнхий удирдамж», хяналт шалгалтын 24180900580 тоот томилолтыг үндэслэн 5669464 дүгээр регистртэй «Евро эйшия реманд пактурин сервис» ХХК-ийн 2013 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2017 оны 12 дугаар сарын 31-нийг дуустал хугацааны татварын ногдуулалт төлөлтөнд иж бүрэн татварын хяналт шалгалт хийж 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдөр 0290951 тоот шийтгэлийн хуудас үйлдсэн болно.

«Евро эйшия реманд пактурин сервис» ХХК нь 5669464 тоот регистр, 9019066085 тоот улсын бүртгэлийн дугаартай, Сонгино хайрхан дүүргийн 20 дугаар хороо Тээвэрчдийн гудамж 24-А «Хера индустрал парк»-д байрладаг, Сингапур улсын «SJ market corporation» Со-ний 100%-ийн хөрөнгө оруулалттай, 138,000,000.00 төгрөгийн дүрмийн сантай, ХААН банкны 5011305095 тоот долларын, 5011297298 тоот төгрөгийн тус тус харилцах данстай, Гадаад худалдаа, уул уурхайн машин тоног төхөөрөмжийн сэлбэгийн худалдаа, уул уурхайн машин тоног төхөөрөмжийн засварын үйлчилгээ эрхлэх чиглэлээр үүсгэн байгуулагдсан, гүйцэтгэх захирал Тайланд улсын иргэн Boonprojana Soontorn Prut нь 2013 оны 09 дүгээр сард томилогдсон, харилцах утас:957252418 /Итгэмжлэгдсэн төлөөлөгч ЧВ67051571 тоот регистртэй Гэндэнсүрэн ургийн Дэмчигжав овогтой Сүхээ: /харилцах утас: 99110957, 253297, 9907831/ 5447178 тоот регистртэй «Бостон стар консалтинг» ХХК-ийн захирал буюу тус компанитай санхүүгийн гэрээ байгуулан ажиллаж байгаа/.

Татварын хяналт шалгалтаар тус компанид дараах зөрчил илэрсэн. Үүнд:

2014 онд 13,036,719.08 төгрөг, 2015 онд 4,677,185.44 төгрөг, 2016 онд 827,000.00 төгрөгийн тус тус компьютер техник хэрэгсэл болон хөрөнгө бэлтгэхэд зориулан худалдан авсан бараа материалд төлсөн нэмэгдсэн өртгийн албан татварыг, нэмэгдсэн өртгийн албан татварын худалдан авалтаас хасч тооцсон нь Нэмэгдсэн өртгийн 14 дүгээр зүйл. «14.1.Хувь хүн, хуулийн этгээдийн албан татвар суутган төлөгчөөр бүртгүүлснээс хойшх хугацаанд энэ хуулийн 7, 8, 11 дүгээр зүйлд заасны дагуу төлсөн доор дурдсан албан татварыг түүний төсөвт төлөх албан татвараас хасч тооцно: 14.4.Дараах бараа, ажил, үйлчилгээг импортоор оруулах, худалдаж авахад төлсөн албан татварыг албан татвар суутган төлөгчийн төлөх уг албан татварын нийт дүнгээс хасахгүй: 14.4.3. энэ хуулийн 13 дугаар зүйлд заасан үйлвэрлэл, үйлчилгээнд зориулж импортлосон болон худалдаж авсан бараа, ажил, үйлчилгээ» гэсэн заалтыг зөрчсөн үйлдэлд Зөрчлийн тухай хуулийн 1.4 дүгээр зүйлийн «3.Зөрчилд тооцох, зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд оногдуулах шийтгэл, албадлагын арга хэмжээний төрөл, хэмжээг тухайн зөрчил үйлдэх үед дагаж мөрдөж байсан хуулийн дагуу шийдвэрлэнэ.», Татварын ерөнхий хуулийн 74 дүгээр зүйл 74.1«Дараахь үйлдэл, эс үйлдэхүйгээр татвар ногдох орлого, орлогоос бусад зүйлийг нуусан татвар төлөгчид эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол татварыг нөхөн төлүүлж, нөхөн төлүүлэх татварын 30 хувьтай тэнцэх хэмжээний торгууль ногдуулна:», 74.1.4. тоо хэмжээ, үнийг нь нягтлан бодох бүртгэл, тайлан тэнцэл, татварын тайланд багасгаж тусгах, эсхүл ийнхүү багасгахын тулд зардал болон бусад хасагдах зүйлийг өсгөх.»), Зөрчлийн тухай хуулийн 1.4 дүгээр зүйл Зөрчлийн тухай хууль үйлчлэх нутаг дэвсгэр, хугацаа 4.Зөрчилд тооцохгүй болсон, оногдуулах шийтгэл, албадлагын арга хэмжээг хөнгөрүүлсэн, зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдийн эрх зүйн байдлыг дээрдүүлсэн хуулийг буцаан хэрэглэнэ. Татварын ерөнхий хуулийн «74.1. Хуульд заасны дагуу нөхөн төлүүлэх болон хугацаанд нь төлөөгүй татварт алданги тооцох бөгөөд уг алдангийн хэмжээ нь нөхөн төлүүлэх татварын үнийн дүнгийн 20 хувиас хэтрэхээргүй байна.» гэж заасныг индэслэн нийт 18,540,904.52 төгрөгийн зөрчилд ногдох 1,854,090.40 төгрөгийн нөхөн татвар, 556,227.20 төгрөгийн торгууль, 370,818.10 төгрөгийн алданги нийт 2,781,135.70 төгрөгийн төлбөр ногдуулсан.

Татвар төлөгч уг хяналт шалгалтаар гарсан зөрчилтэй бүрэн танилцаж, зөвшөөрөн гарын үсэг зурж, 1 хувийн хүлээж авсан боловч Нийслэлийн Татварын газрын Маргаан таслах зөвлөлд тус татвар төлөгч гомдол гаргасан байна. Иймээс гаргасан гомдолд татварын улсын байцаагч дараахь тайлбарыг хүргүүлж байна. Үүнд:

1. Тус татвар төлөгч 2014 онд 13,036,719.08 төгрөг, 2015 онд 4,677,185.44 төгрөгийн тус тус компьютер техник хэрэгсэл болон хөрөнгө бэлтгэхэд зориулан

худалдан авсан бараа материалд төлсөн нэмэгдсэн өртгийн албан татварыг, нэмэгдсэн өртгийн албан татварын худалдан авалтаас хасч тооцсон нь 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө мөрдөгдөж байсан НӨАТ-ын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1 дэх хэсэгт "үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар худалдан авсан бараа, гүйцэтгэсэн ажил, үйлчилгээнд ..." гэсэн заалтаар төсөвт төлөх албан татвараас хасч тооцох үндэслэл болохгүй гэсэн чиглэлийг мөрдөж ажилласан болно. Энэ чиглэл нь Татварын ерөнхий газрын Хяналт шалгалт арга зүйн газрын дарга С.Баясгалангийн 2017 оны 01 сарын 05-ны өдрийн 07/65 тоотод нарийвчлан тусгасан байгаа. /Албан тоотыг хавсаргав/.

2. 2016 онд 827,000.00 төгрөгийн тус тус компьютер техник хэрэгсэл болон хөрөнгө бэлтгэхэд зориулан худалдан авсан бараа материалд төлсөн нэмэгдсэн өртгийн албан татварыг, нэмэгдсэн өртгийн албан татварын худалдан авалтаас хасч тооцсон нь нэмэгдсэн өртгийн албан татварын хуулийн заалтыг зөрчсөн байна. Энэ падааны задаргааг хавсралтаар хүргүүлэв." гэж тэмдэглэсэн

3. Магадлагч-татварын улсын байцаагч Татварын маргаан таслах зөвлөлийн ажиллах журмын 6 дугаар зүйлд заасан эрх, үүргийн дагуу оролцогч талуудаас ирүүлсэн гомдол, тайлбар, татварын болон санхүүгийн тайлан, анхан шатны баримт, журналын бүртгэл зэрэг холбогдох материалд тулгуурлан Татварын маргаан таслах зөвлөлийн ажиллах журмын 3 дугаар зүйл болон бусад хууль тогтоомжид үндэслэн магадалгаа хийж, татварын улсын байцаагчийн 0290951 тоот шийтгэлийн хуудсаар 1,854,090.40 төгрөгийн татвар, 556,227.20 төгрөгийн торгууль, 370,818.10 төгрөгийн алданги нийт 2,781,135.70 төгрөгийн төлбөр нөхөн төлүүлэхээр шийдвэрлэснээс 2014 оны 13,036,719.08 төгрөг, 2015 оны 4,677,185.44 төгрөгийн зөрчилд ногдох 1,771,390.40 төгрөгийн татвар, 531,417.12 төгрөгийн торгууль, 354,278.00 төгрөгийн алдангийг хүчингүй болгох, 2016 оны 827,000.00 төгрөгийн зөрчилд ногдох 82,700.00 төгрөгийн татвар, 24,810.08 төгрөгийн торгууль, 16,540.10 төгрөгийн алдангийг хэвээр үлдээх гэсэн саналыг оруулсан.

#### **ҮНДЭСЛЭХ НЬ:**

"Евро эйшия реманд пактурин сервис" компанийн 2013-2017 оны албан татварын ногдуулалт, төлөлтийн байдалд Баянзүрх дүүргийн Татварын хэлтсийн татварын улсын байцаагч Ш.Гэрэлзаяа, Г.Баярмаа нар Татварын ерөнхий газрын хяналт шалгалт хийх удирдамжийн дагуу шалгалт хийж, татварын улсын байцаагчийн 24180900580 дугаар шийтгэлийн хуудсаар 18,540,904.5 төгрөгийн зөрчил илрүүлж, 1,854,090.4 төгрөгийн нөхөн татвар, 556,227.2 төгрөгийн торгууль, 370,818.1 төгрөгийн нийт 2,871,135.7 төгрөгийн төлбөр ногдуулсныг эс зөвшөөрч гомдол гаргажээ.

Татварын албаны цахим бүртгэлийн системд /<http://bi.mta.mn/> хадгалагдсан тайлангийн нэгтгэлээс "Евро эйшия реманд пактурин сервис" ХХК нь 2014, 2015 онуудад нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөгдөх орлого тайлагнаагүй байна.

Иймд Нэмэгдсэн өртгийн албан татварын хуулийн /2006 оны/ 14 дүгээр зүйлийн 14.4.3-д «энэ хуулийн 13 дугаар зүйлд заасан үйлдвэрлэл, үйлчилгээнд зориулж импортолсон болон худалдаж авсан бараа, ажил үйлчилгээ» гэсэн заалтыг зөрчөөгүй, мөн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д «Иргэн хуулийн этгээд нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчөөр бүртгүүлснээсээ хойшхи хугацаанд энэ хуулийн 7, 8, 11 дүгээр зүйлд заасны дагуу төлсөн дор дурдсан нэмэгдсэн өртгийн албан татварыг түүний төсөвт төлөх нэмэгдсэн өртгийн албан татвараас хасч тооцно: 14.1.1 үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар худалдан авсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээнд төлсөн», мөн Сангийн сайдын 2009 оны 12 сарын 15-ны 283 тоот тушаалаар Нэмэгдсэн өртгийн албан татварын хасалт хийх, буцаан олгох, тэдгээрийг нягтлан бодох бүртгэлд тусгахтай холбогдсон харилцааг зохицуулах журмын 5 дугаар

зүйл 5.1.4-д «барилга байгууламж, техник, тоног төхөөрөмж худалдан авах болон ашиглагдаж байгаа барилга байгууламж, техник тоног төхөөрөмжийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, ашиглалтын хугацааг уртасгах үйл ажиллагаанд зориулан тухайн тайлангийн хугацаанд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээнд төлсөн НӨАТ-ын нийт дүнгээс НӨАТ-аас чөлөөлөгдөх үйлдвэрлэл, үйлчилгээнд ашиглагдаж байгаа барилга, байгууламж, техник, тоног төхөөрөмжийг худалдан авах болон тэдгээрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, ашиглалтын хугацааг уртасгах үйл ажиллагаанд зориулан худалдан авсан бараа, ажил, үйлчилгээнд төлсөн НӨАТ-ыг хасч, хасагдах дүнг тодорхойлно», мөн журмын 7 дугаар зүйлийн 7.4-д «мөнгөн орлогын журнал», «борлуулалтын журнал»-уудыг үндэслэн борлуулсан бараа, ажил үйлчилгээндээ ногдуулан худалдан авагчаас нэхэмжилсэн буюу тухайн тайлангийн хугацаанд ногдуулсан НӨАТ-ын хэмжээг, «мөнгөн зарлагын журнал»-ыг үндэслэн худалдан авсан бараа, ажил үйлчилгээнд төлсөн буюу тухайн тайлангийн хугацаанд хасагдах НӨАТ-ын хэмжээг тус тус тодорхойлно» гэсэн заалтын дагуу худалдан авалтын хасалт хийсэн нь хууль зөрчөөгүй байна.

Иймд 17,713,904.4 төгрөгийн зөрчилд ногдуулсан 1,771,390.4 төгрөгийн нөхөн татвар, 531,417.2 төгрөгийн торгууль, 885,695.3 төгрөгийн алданги нийт 2,657,085.7 төгрөгийн төлбөрийг хүчингүй болгох нь зүйтэй гэж зөвлөлийн бүрэлдэхүүн дүгнэлээ.

Харин 2016 онд 827,000.0 төгрөгийн компьютер тоног төхөөрөмж худалдан авахад төлсөн нэмэгдсэн өртгийн албан татварыг худалдан авалтын хасалт хийсэн нь Нэмэгдсэн өртгийн албан татварын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх заалтыг зөрчсөн байх тул Зөрчлийн тухай хуулийн 1.4 дүгээр зүйлийн «3.Зөрчилд тооцох, зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд оногдуулах шийтгэл, албадлагын арга хэмжээний төрөл, хэмжээг тухайн зөрчил үйлдэх үед дагаж мөрдөж байсан хуулийн дагуу шийдвэрлэнэ.», Татварын ерөнхий хуулийн 74 дүгээр зүйл 74.1 «Дараахь үйлдэл, эс үйлдэхүйгээр татвар ногдох орлого, орлогоос бусад зүйлийг нуусан татвар төлөгчид эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол татварыг нөхөн төлүүлж, нөхөн төлүүлэх татварын 30 хувьтай тэнцэх хэмжээний торгууль ногдуулна:», 74.1.4. тоо хэмжээ, үнийг нь нягтлан бодох бүртгэл, тайлан тэнцэл, татварын тайланд багасгаж тусгах, эсхүл ийнхүү багасгахын тулд зардал болон бусад хасагдах зүйлийг өсгөх.», Зөрчлийн тухай хуулийн 1.4 дүгээр зүйл .Зөрчлийн тухай хууль үйлчлэх нутаг дэвсгэр, хугацаа 4.Зөрчилд тооцохгүй болсон, оногдуулах шийтгэл, албадлагын арга хэмжээг хөнгөрүүлсэн, зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдийн эрх зүйн байдлыг дээрдүүлсэн хуулийг буцаан хэрэглэнэ. Татварын ерөнхий хуулийн «74.1. Хуульд заасны дагуу нөхөн төлүүлэх болон хугацаанд нь төлөөгүй татварт алданги тооцох бөгөөд уг алдангийн хэмжээ нь нөхөн төлүүлэх татварын үнийн дүнгийн 20 хувиас хэтрэхээргүй байна.» гэж заасныг үндэслэн 82,700.0 төгрөгийн нөхөн татвар, 24,180.0 төгрөгийн торгууль, 16,540.0 төгрөгийн алданги нийт 124,050.0 төгрөгийн төлбөрийг төлүүлэх нь зүйтэй гэж зөвлөлийн бүрэлдэхүүн шийдвэрлэлээ.

Татварын ерөнхий хуулийн 42 дугаар зүйлийн 7 дахь заалтыг удирдлага болгон

#### ТОГТООХ НЬ:









1. Татварын ерөнхий хуулийн 74 дүгээр зүйлийн 74.1.4, Зөрчлийн тухай хуулийн 1.4 дүгээр зүйлийн 1.4.3, 1.4.4, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1, 14.4.3 дах заалтуудыг үндэслэн татварын улсын байцаагчийн 250012662 шийтгэлийн хуудсаар 18,540,904.5 төгрөгийн зөрчил илрүүлж, 1,854,090.4 төгрөгийн нөхөн татвар, 556,227.0 төгрөгийн торгууль, 370,818.1 төгрөгийн алданги нийт 2,781,135.7 төгрөгийн төлбөр ногдуулснаас Нэмэгдсэн өртгийн албан татварын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1, Сангийн сайдын 2009 оны 12 сарын 15-ны 283 тоот

тушаалаар Нэмэгдсэн өртгийн албан татварын хасалт хийх, буцаан олгох, тэдгээрийг нягтлан бодох бүртгэлд тусгахтай холбогдсон харилцааг зохицуулах журмын 5 дугаар зүйл 5.1.4, 7 дугаар зүйлийн 7.4 дэх заалтыг үндэслэн 17,713,904.4 төгрөгийн зөрчилд ногдуулсан 1,771,390.4 төгрөгийн нөхөн татвар, 531,417.2 төгрөгийн торгууль, 885,695.3 төгрөгийн алданги нийт 2,657,085.7 төгрөгийн төлбөрийг хүчингүй болгох, 827,000.0 төгрөгийн зөрчилд ногдуулсан 82,700.0 төгрөгийн нөхөн татвар, 24,180.0 төгрөгийн торгууль, 16,540.0 төгрөгийн алданги нийт 124,050.0 төгрөгийн төлбөрийг төлүүлэхээр татварын улсын байцаагчийн шийтгэлийн хуудсыг өөрчилсүгэй.

2. Шийдвэрийг эс зөвшөөрвөл шийтгэлийн хуудсанд гомдол гаргагч, түүний төлөөлөгч, өмгөөлөгч шийдвэрийг гардан авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор дээд шатны татварын албаны дэргэдэх маргаан таслах зөвлөл болон Захиргааны хэргийн шүүхэд гомдол гаргах эрхтэй.

ХУРАЛ ДАРГАЛСАН:

ГИШҮҮД :

	Д.САЙХАНЧУЛУУН
	Ц.АЛТАНЦЭЦЭГ
	Х.ТӨМӨРБААТАР
	Ё.НАРАНБИЛЭГ
	Д.БАЯРАА
	Д.МӨНХТУУЛ
	Б.ТӨГСЛХАМ
	Ж.ЭРДЭНЭБҮРЭН